

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/69/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2021  
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН  
ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigiargalts@audit.gov.mn](mailto:khishigiargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70273204 Цахим хаяг: [byambatsogtj@audit.gov.mn](mailto:byambatsogtj@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)

## Агуулга

---

Товчилсон үгийн жагсаалт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	8
2.4Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Материаллаг байдал .....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал .....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	17
4. Аудитын илрүүлэлт .....	17
4.1 Залруулсан алдаа .....	18
4.2 Албан шаардлага .....	19
4.3 Зөвлөмж.....	20

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

ТӨВ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА В.БОЛОРТУЯА ТАНАА

### **Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Жаргалант сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Жаргалант сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### **Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>87,272,823.09</b>	<b>71,703,045.44</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>1,510,200.00</b>	<b>1,510,200.00</b>
335	Бусад авлага	1,510,200.00	1,510,200.00
351	Түүхий эд материал	6,887,558.00	6,869,558.00
35110	Тусгай зориулалттай материал	6,887,558.00	6,869,558.00
<b>35410</b>	<b>Бичиг хэргийн материал</b>	<b>483,600.00</b>	<b>582,200.00</b>
35420	Аж ахуйн материал	2,015,200.00	2,015,200.00
35430	Сэлбэг хэрэгсэл	21,571,500.00	22,566,500.00
35440	Түлш, шатах тослох материал	6,309,240.65	1,708,463.00
35450	Барилгын засварын материал	756,600.00	756,600.00
35470	Бусад хангамжийн материал	47,738,924.44	35,694,324.44
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,061,259,220.70</b>	<b>1,918,030,193.56</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>2,061,259,220.70</b>	<b>1,918,030,193.56</b>
392	Биет хөрөнгө	1,908,955,220.70	1,765,726,193.56
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,371,170,923.32	1,386,170,923.32
39202	Хуримтлагдсан элэгдэл	(193,528,538.14)	(386,189,297.22)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	365,232,256.61	365,232,256.61
<b>39204</b>	<b>Хуримтлагдсан элэгдэл</b>	<b>(216,925,733.55)</b>	<b>(240,520,416.87)</b>
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	167,097,419.29	175,961,023.29
39206	Хуримтлагдсан элэгдэл	(113,282,078.83)	(132,831,952.83)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	71,810,903.00	71,810,903.00
<b>39208</b>	<b>Хуримтлагдсан элэгдэл</b>	<b>(34,648,676.53)</b>	<b>(37,500,898.05)</b>
<b>39214</b>	<b>Бусад үндсэн хөрөнгө</b>	<b>672,322,884.00</b>	<b>765,352,884.00</b>
39215	Хуримтлагдсан элэгдэл	(180,294,138.47)	(201,759,231.69)
393	Биет бус хөрөнгө	152,304,000.00	152,304,000.00
39301	Програм хангамж	450,000.00	450,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(450,000.00)	(450,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	152,304,000.00	152,304,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,148,532,043.79</b>	<b>1,989,733,239.00</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,148,532,043.79</b>	<b>1,989,733,239.00</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>2,148,532,043.79</b>	<b>1,989,733,239.00</b>
<b>511</b>	<b>Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон</b>	<b>460,393,479.67</b>	<b>460,393,479.67</b>
<b>51101</b>	<b>Өмч: - төрийн</b>	<b>460,393,479.67</b>	<b>460,393,479.67</b>
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>977,039,663.65</b>	<b>818,240,858.86</b>
<b>51210</b>	<b>Өмнөх үеийн үр дүн</b>	<b>977,039,663.65</b>	<b>977,039,663.65</b>
<b>51220</b>	<b>Тайлант үеийн үр дүн</b>	<b>-</b>	<b>(158,798,804.79)</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	898,975,473.82	611,078,234.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	323,245,278.00	137,382,650.00
120	Нийтлэг татварын бус орлого	323,245,278.00	137,382,650.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	323,245,278.00	137,382,650.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	195,000,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	137,382,650.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	575,730,195.82	473,695,584.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	536,471,300.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	536,471,300.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	39,258,895.82	65,041,734.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	18,350,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц	2,500,000.00	14,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	27,010,722.90	29,675,234.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд	9,748,172.92	3,016,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	408,653,850.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт	-	408,653,850.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	708,810,938.45	756,796,908.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	692,987,758.45	756,796,908.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	543,229,372.07	742,000,961.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	258,994,723.99	260,555,580.00
210101	Үндсэн цалин	160,429,695.60	159,047,537.47
210102	Нэмэгдэл	38,788,177.08	42,294,324.05
210105	Гэрээт ажлын хөлс	59,776,851.31	59,213,718.48
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,127,833.45	36,128,437.47
210201	Тэтгэврийн даатгал	23,392,023.98	25,486,851.37
210202	Тэтгэмжийн даатгал	2,721,913.41	2,784,526.14
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,137,190.66	2,164,974.34
210204	Ажилгүйдлийн даатгал	533,681.56	511,299.21
210205	Эрүүл мэндийн даатгал	5,343,023.84	5,180,786.41
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,624,258.36	47,987,929.52
210301	Гэрэл, цахилгаан	9,019,716.00	12,340,494.88
210302	Түлш, халаалт	43,604,542.36	35,647,434.64
2104	Хангамж, бараа материалын зардал	19,112,217.00	32,616,471.92
210401	Бичиг хэрэг	3,653,756.00	2,602,000.00
210402	Тээвэр, шатахуун	10,657,270.00	11,330,175.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,105,551.00	1,368,410.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал,	-	12,797,886.92
210408	Бараа материал акталсны зардал	695,640.00	4,518,000.00
2105	Нормативт зардал	1,644,300.00	726,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,644,300.00	726,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,165,890.00	661,000.00
210604	Урсгал засвар	2,165,890.00	661,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,026,500.00	538,000.00

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210702	Дотоод албан томилолт	2,026,500.00	538,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	66,099,246.00	27,084,076.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	64,684,022.00	25,586,276.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	320,000.00	604,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	400,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	545,224.00	750,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	150,000.00	143,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	106,434,403.27	335,703,166.70
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,092,610.00	73,813,969.64
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	86,341,793.27	261,889,197.06
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	149,758,386.38	14,795,947.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,460,300.00	400,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	6,700,300.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	760,000.00	400,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	142,298,086.38	14,395,947.10
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	142,298,086.38	14,395,947.10
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	15,823,180.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	15,823,180.00	-
221001	Их засвар	824,780.00	-
223001	Бусад хөрөнгө	14,998,400.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	190,164,535.37	(145,718,674.71)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	11,132,608.21	13,080,130.08
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	702,708.21	4,689,980.08
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(11,132,608.21)	(13,080,130.08)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	179,031,927.16	(158,798,804.79)

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	770,730,195.82	473,695,584.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	195,000,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	195,000,000.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	195,000,000.00	-
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	195,000,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	575,730,195.82	473,695,584.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	536,471,300.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	536,471,300.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	39,258,895.82	65,041,734.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив,	-	18,350,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц	2,500,000.00	14,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс	27,010,722.90	29,675,234.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий	9,748,172.92	3,016,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	408,653,850.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт	-	408,653,850.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	609,080,085.82	472,195,584.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	609,080,085.82	472,195,584.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	459,321,699.44	457,399,636.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	258,994,723.99	260,555,580.00
210101	Үндсэн цалин	160,429,695.60	159,047,537.47
210102	Нэмэгдэл	38,788,177.08	42,294,324.05
210105	Гэрээт ажлын хөлс	59,776,851.31	59,213,718.48
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,127,833.45	36,128,437.47
210201	Тэтгэврийн даатгал	23,392,023.98	25,486,851.37
210202	Тэтгэмжийн даатгал	2,721,913.41	2,784,526.14
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,137,190.66	2,164,974.34
210204	Ажилгүйдлийн даатгал	533,681.56	511,299.21
210205	Эрүүл мэндийн даатгал	5,343,023.84	5,180,786.41
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,645,399.00	43,130,961.88
210301	Гэрэл, цахилгаан	9,019,716.00	12,340,494.88
210302	Түлш, халаалт	45,625,683.00	30,790,467.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,292,457.00	28,483,071.92
210401	Бичиг хэрэг	3,529,636.00	2,700,600.00
210402	Тээвэр, шатахуун	10,657,270.00	11,616,175.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	1,368,410.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	12,797,886.92
2105	Нормативт зардал	1,283,250.00	926,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,283,250.00	926,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	661,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	661,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,026,500.00	538,000.00
210702	Дотоод албан томилолт	2,026,500.00	538,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	69,354,896.00	27,011,076.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	67,939,672.00	25,513,276.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	320,000.00	604,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	400,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	545,224.00	750,000.00

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	150,000.00	143,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,596,640.00	59,965,409.63
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,596,640.00	59,835,409.63
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	130,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	149,758,386.38	14,795,947.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,460,300.00	400,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	6,700,300.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	760,000.00	400,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	142,298,086.38	14,395,947.10
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	142,298,086.38	14,395,947.10
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	161,650,110.00	1,500,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	161,650,110.00	1,500,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	161,650,110.00	1,500,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	161,650,110.00	1,500,000.00
221001	Их засвар	824,780.00	-
222001	Тоног төхөөрөмж	11,310,000.00	-
223001	Бусад хөрөнгө	14,998,400.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	134,516,930.00	1,500,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН	(161,650,110.00)	(1,500,000.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	460,393,479.67	711,382,608.05	674,373,580.53	1,846,149,668.25
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	167,083.02	167,083.02
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	460,393,479.67	711,382,608.05	674,540,663.55	1,846,316,751.27
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-72,495,195.61	-72,495,195.61
C08	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	460,393,479.67	711,098,900.47	977,039,663.65	2,148,532,043.79
D01	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	460,393,479.67	711,098,900.47	977,039,663.65	2,148,532,043.79
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	460,393,479.67	711,098,900.47	977,039,663.65	2,148,532,043.79
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-158,798,804.79	-158,798,804.79
D09	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	460,393,479.67	711,098,900.47	818,240,858.86	1,989,733,239.00

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	501,203,500.00	400,251,805.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	501,203,500.00	400,251,805.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	500,703,500.00	399,851,805.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	280,936,900.00	260,555,580.00
210101	Үндсэн цалин	175,213,800.00	159,047,537.47
210102	Нэмэгдэл	41,021,600.00	42,294,324.05
210105	Гэрээт ажлын хөлс	64,701,500.00	59,213,718.48
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,926,600.00	36,128,437.47
210201	Тэтгэврийн даатгал	26,689,000.00	25,486,851.37
210202	Тэтгэмжийн даатгал	2,809,400.00	2,784,526.14
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,247,500.00	2,164,974.34
210204	Ажилгүйдлийн даатгал	561,900.00	511,299.21
210205	Эрүүл мэндийн даатгал	5,618,800.00	5,180,786.41
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	65,431,500.00	43,130,961.88
210301	Гэрэл, цахилгаан	16,748,400.00	12,340,494.88
210302	Түлш, халаалт	48,587,100.00	30,790,467.00
210303	Цэвэр, бохир ус	96,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	32,596,500.00	28,062,796.92
210401	Бичиг хэрэг	3,052,500.00	2,455,600.00
210402	Тээвэр, шатахуун	10,936,000.00	11,440,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,608,000.00	1,368,410.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	17,000,000.00	12,797,886.92
2105	Нормативт зардал	1,100,000.00	926,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,100,000.00	926,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	661,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	661,000.00
2107	Томиллолт, зочны зардал	4,665,700.00	538,000.00
210702	Дотоод албан томиллолт	4,665,700.00	538,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,904,800.00	1,497,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.00	604,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	400,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	750,000.00	750,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	150,000.00	143,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	75,141,500.00	28,351,129.63
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	75,141,500.00	28,351,129.63
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	500,000.00	400,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	400,000.00
0	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	501,203,500.00	408,653,850.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	450,937,000.00	408,653,850.00
132001	Орон нутгийн төсвөөс	450,937,000.00	408,653,850.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	50,266,500.00	-
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	50,266,500.00	-

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	59,047,831.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	31,143,953.00	59,047,831.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	31,143,953.00	59,047,831.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	420,275.00
210401	Бичиг хэрэг	-	245,000.00
210402	Тээвэр, шатахуун	-	175,275.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	14,533,393.00	25,513,276.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйл	14,533,393.00	25,513,276.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,610,560.00	33,114,280.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,610,560.00	32,984,280.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	130,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	39,258,895.82	65,041,734.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	39,258,895.82	65,041,734.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээ	-	18,350,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагда	-	11,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгаг	29,540,722.90	32,696,234.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагаан	9,718,172.92	2,995,500.00
0	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
0	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Жаргалант сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Жаргалант сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Жаргалант сумын ЗДТГ нь сумын ИТХ, Засаг даргын бодлого боловсруулж, шийдвэр гаргахад нь бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэх замаар төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэн төрийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, иргэдийн ажиллах амьдрах таатай орчин бүрдүүлэх, оновчтой бодлого зохицуулалтаар хангах замаар аймгийнхаа хөгжилд дэмжлэг үзүүлж чаддаг, цомхон чадварлаг, эцсийн үр дүнг эрхэмлэн дээдэлсэн төрийн албыг төлөвшүүлэх чиг үүрэг бүхий байгууллага юм.

Жаргалант сумын ЗДТГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

Үүнд:

- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,
- Засаг даргаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалт, эрх зүй, аж ахуйн талаар болон Тамгын газрын хэлтэс, албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах,
- Нутгийн захиргааны байгууллагыг чиглүүлэн удирдахад нь Засаг даргад туслах, Хурал, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах, хууль тогтоомж, Засгийн газар, Хурал, Засаг даргын шийдвэрийг биелүүлэх үүрэг бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавьж үр дүнг тооцох
- Тамгын газрын бичиг хэргийг хөтлөх, байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, төрийн захиргааны ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн бодлогыг шинээр боловсруулан мөрдөн ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

ЗДТГ-ын даргын 2021 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн № А/26 тоот тушаалаар дотоод хяналтын нэгжийг хариуцсан албан тушаалтнаар хууль эрх зүйн мэргэжилтэнг томилж, бүрэлдэхүүнийг хяналт хийх тухай бүрд нь удирдамжаар томилдог байна. ЗДТГ-ын даргын тушаалаар 2021 оны дотоод хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө хуваарийг баталсан.

Дотоод хяналт шалгалтын удирдамжид заасны дагуу санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих, анхан шатны бүрдүүлэлт, өмчийн бүртгэл тооцоо ашиглалт хадгалалтад хяналт тавих, нярав складын бүртгэлийн эмч цэгц, байгууллагад шинээр авсан эд хөрөнгө болон хандив тусламжийн хөрөнгүүдийг бүртгэлд авсан эсэхэд хяналт тавих, шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэл суулгасан явцад хяналт тавихаар тусгасан байна.

Төв аймгийн Жаргалант сумын ЗДТГ-ын дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Жаргалант сумын ЗДТГ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 898,975.5 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 13,484.6 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 10,113.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Энэ нь төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт орлогоос тооцсон тул дахин тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 569,046.9 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 8,535.7 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 6,401.8 мянган төгрөгөөр тогтоосон. Дахин тооцсон материаллаг байдлын түвшин нь төлөвлөлтийн үе шатнаас 4,948.9 мянган төгрөгөөр буурсан байна.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Жаргалант сумын ЗДТГ нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, МУ-ын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, ТБОНӨ-ийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

#### **Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:**

Тус байгууллага нь 2021 онд орон нутгийн төсвөөс 450,937.0 мянган төгрөгийн санхүүжилт авахаас 408,653.8 мянган төгрөг буюу 90,6% байна. Нэмэлт санхүүжилтийн дансанд ААНБ, иргэдээс 18,350.0 мянган төгрөгийн хандив тусламж, ЗГНХ, ЗДНХ-өөс 14,000.0 мянган төгрөгийн санхүүжилт, дээд шатны төсвийн захирагчаас 29,675.2 мянган төгрөг, төсөвт газрын өөрийн орлого 3,016.5 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна. Мөнгөн гүйлгээний тайлангаар нийт 473,695.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

#### **Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:**

Үндсэн хөрөнгө дансанд Төв аймгийн ЗДТГ-аас 6,228.6 мянган төгрөг, Тэнхун ХХК-иас 2,656.0 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 63,750.0 мянган төгрөг, Дэлхийн зөн ХХК-иас 7,537.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж багаж хэрэгсэл хандивласныг бүртгэж тайлагнасан байна.

Бараа материалын дансанд ОБГ-аас үнэ төлбөргүй шилжүүлсэн 1,075.0 мянган төгрөгийн хүнс дархлаажуулалтын багц, ОНХС-аас 7,952.0 мянган төгрөгийг гэрэлтүүлэг засвар, 6 ААНБ-аас 6,782.5 мянган төгрөг, 17 иргэнээс 3,298.0 мянган төгрөгийн хүнс болон хамгаалах хэрэгсэл, бичиг хэрэг, ШТМ, бараа материалыг хандивын орлогоор бүртгэсэн байна. Нийт 64,630.8 мянган төгрөгийн бараа материалыг орлогод авч, 4,668.0 мянган төгрөгийн бараа материал акталж устган 6,890.0 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, ариутгал цэвэрлэгээ хамгаалах хэрэгслийг бусад байгууллагад шилжүүлж, 83,820.7 мянган төгрөгийн бараа материал зарлагдсан байна.

#### **Авлага, өглөгийн талаар:**

2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар урьд оны авлагын үлдэгдэл 1,510.2 мянган төгрөг бөгөөд, шинээр авлага үүсээгүй байна.

#### **Санхүүгийн байдлын тайлангийн талаар:**

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>Б</b>	1.00	2.00	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	1,510.20	1,510.20	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	85,762.62	70,192.85	(15,569.78)
Үндсэн хөрөнгө	2,061,259.22	1,874,852.54	(186,406.68)
Нийт хөрөнгө	2,148,532.04	1,946,555.58	(201,976.46)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо	2,148,532.04	1,946,555.58	(201,976.46)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,148,532.04	1,946,555.58	(201,976.46)

2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар харилцах дансны үлдэгдэл 0 төгрөг, Авлага данс 1510.2 мянган төгрөг, бараа материал 70,192.8 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 1874852,5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Авлагын дансны үлдэгдэл нь өөрчтөлтгүй өмнөх оны мөн үеийн үзүүлэлтээр хэвээр байна. Бараа материалын дансны үлдэгдэл 70,192,8 мянган төгрөг болж 15.569,8 мянган төгрөг болж буурсан нь 4650,0 мянган төгрөгийн бараа материал акталж устган, 6150,1 мянган төгрөгийн бараа материалын бусад байгууллагад шилжүүлж, мөн оны эхний үлдэгдлээс зарцуулалт хийснээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл цэвэр дүн 1,874,852,5 мянган төгрөг болж 186,407,0 мянган төгрөгөөр буурсан нь 80 172,5 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хөрөнгө шинээр орлогод авсан боловч 6456,5 мянган төгрөгийн хөрөнгө акталж устгаж тайлант үеийн элэгдлийн зардал өссөнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,946,555,6 мянган төгрөг болж 201,976,4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 317,895.6 мянган төгрөгөөр төлөвлөн дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 63,578.9 мянган төгрөгөөр бууруулан 254,316.7 мянган төгрөгийн урсгал зардлыг санхүүжүүлэхээр баталсан байна. Энэ нь байр ашиглалттай холбоотой зардал, хангамжийн зардал, нормативд зардал хасагдсантай холбоотой байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар орон нутгийн төсвөөс 408,653.6 мянган төгрөгийн санхүүжилт авч үндсэн үйл ажиллагаанд 391,449.8 мянган төгрөг, тэтгэмж урамшуулалд 400.0 мянган төгрөг зарцуулж, 8,402.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Ковид-19 цар тахалтай холбоотойгоор ААНБ, иргэдээс 18,350.0 мянган төгрөгийн хандив тусламж, ЗГНХ, ЗДНХ-өөс 14,000.0 мянган төгрөгийн санхүүжилт, дээд шатны төсвийн захирагчаас 29,675.2 мянган төгрөг, төсөвт газрын өөрийн орлого 3,016.5 мянган төгрөг нийт 65,041.7 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Жаргалант сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд онцлох асуудал байхгүй байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Кассын данс болон ХААН банкны 5740184307 дугаарын дансаар хийгдсэн 2,753.2 мянган төгрөгийн гүйлгээг бүртгэж тайлагнаагүй.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд 149 мэдээлэл байршуулахаас 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан төлөвтэй байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөж, бараа материалыг зөв ангилан бүртгэж тайлагнах гэсэн зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн №67 тоот албан бичгээр ирүүлж зөрчлийг таслан зогсоосон байна.

#### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Төв аймгийн Жаргалант сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал авлага барагдуулалтыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

### **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 69,248.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 17,645.9 мянган төгрөгийн алдааг залруулж, татварын цахим төлбөрийн баримт, НББ-тэй холбоотой 50,092.0 мянган

төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, авлага барагдуулалттай холбоотой 1,510.2 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгөв.

#### 4.1 Залруулсан алдаа

4.1.1 Зарцуулагдаагүй үлдэгдэл **14,395.9** мянган төгрөгийг төвлөрүүлэхдээ мөнгөн гүйлгээний тайлан, мөнгөн гүйлгээний журналд өөр өөр дансанд бичилт хийсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 8 дугаар зүйлийн 8.1-д “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар” -ын 8-р заалтыг болон санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д "аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх." гэсэн заалтыг үндэслэж залруулга хийсэн.

4.1.2 Сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/268 дугаарын захирамжаар нэр бүхий 15 иргэнд буцалтгүй тусламж **1,500.0** мянган төгрөг олгосон ажил гүйлгээг бүртгэхдээ авлага дансанд бүртгэж зардал дансанд бүртгэж тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 8 дугаар зүйлийн 8.1-д “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар” -ын 8-р заалтыг болон санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д "аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх." гэсэн заалтыг үндэслэж залруулга хийсэн.

4.1.3 Майбридж ХХК-иас хандивласан **250.0** мянган төгрөгийн амны хаалтыг орлогод авахдаа орлогын зүйлийг төсвийн хөрөнгөөр худалдаж авснаар тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 8 дугаар зүйлийн 8.1-д “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь

дараах бүрэлдэхүүнтэй байна”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар” -ын 8-р заалтыг болон санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д "аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх." гэсэн заалтыг үндэслэж залруулга хийсэн.

4.1.4 Бараа үйлчилгээний бусад зардал **1,500.0** мянган төгрөгийг мөнгөн гүйлгээний тайлан, мөнгөн суурьт шалгах баланс, мөнгөн гүйлгээний журналын дүнг зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 8 дугаар зүйлийн 8.1-д “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар” -ын 8-р заалтыг болон санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д "аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх." гэсэн заалтыг үндэслэж залруулга хийсэн.

## 4.2 Албан шаардлага

4.2.1 Харилцагч байгууллагатай хийсэн **47,338.8** мянган төгрөгийн худалдан авалтыг татварын цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй зөрчил илэрлээ. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын НХМаягт 5 “Төлбөрийн баримт нь ... Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд ...” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.6-д “Аудитаар илэрсэн зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй” бол албан шаардлага өгөх гэсэн заалтыг үндэслэн шийдвэрлэв.

4.2.2 Төрийн сангийн харилцах данснаас касст орлого авахдаа арилжааны банкны 5740184307 дугаар дансаар дамжуулан хийсэн **2,753.1** мянган төгрөгийн гүйлгээг тайлагнаагүй байна. Энэ нь 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна..

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.1-д “нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж баталгаажуулаагүй” бол албан шаардлага өгөх гэсэн заалтыг үндэслэн шийдвэрлэв.

#### 4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Авлага данстай холбоотой асуудал

###### 1.1. Илрүүлэлт:

Бусад зардлын тооцооны авлага 1,510.2 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй, арга хэмжээ авч ажиллаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

###### 1.2. Өгсөн зөвлөмж:

Он дамжсан 1,510.2 мянган төгрөгийн авлагыг барагдуулж цаашид авлага, өр үүсгэхгүй байх, Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс					
				Залруулга		Зөвлөмж		Албан шаардлага	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Жаргалант сумын ЗДТГ	7	69,248.1	4	17,645.9	1	1,510.2	2	50,092.0